

“МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ: СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ”

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын стратегийн асуудлаар эрдэм шинжилгээний бие даасан шинэ бүтээл анх удаа хятад хэлээр БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотноо саяхан хэвлэгдэж гарлаа. “Монгол Улсын Аюулгүй байдлын стратеги: судалгаа, дүн шинжилгээ” хэмээх энэхүү бүтээлийг манай улсын Шинжлэх Ухааны Академийн Олон Улс Судлалын Хүрээлэнгээс эрхлэн нийтлүүлжээ.

Нийт арван нэгэн бүлэг, 35 зүйл болон олон гэрэл зургаас бүрдсэн, хятад ханзын 316 хуудастай судалгааны болон танин мэдэхүйн ач холбогдол бүхий уг номыг Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, доктор, профессор Л.Хайсандай, өөрийнхөө шавь БНХАУ-ын эрдэмтэн, Боржигин Сэчинбатын хамт бичжээ.

XXI зуунд Монгол Улсын оршин тогтнохын үндэс болсон үндэсний аюулгүй байдлын стратегийн олон талт асуудлыг тал бүрээс нь судалж нягталж авч үзэх оролдлого хийсэн эрдэм шинжилгээний энэхүү зохиол нь БНХАУ, Монгол Улсын төдийгүй хятад хэл бүхий Азийн ба дэлхийн бусад олон улс орны улс төр, эрдмийн хүрээнийхний болон өргөн олон нийтийн анхаарал, сонирхлыг зүй ёсоор татах нь дамжиггүй.

